



**“ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**“ЦАЙНЫ ГАЗРЫН ТОХИЖИЛТЫН ИЖ БҮРДЭЛ, ГАЛ ТОГООНЫ
САНДАЛ ШИРЭЭ НИЙЛҮҮЛЭХ” НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: “Цайны газрын тохижилтын иж бүрдэл, гал тогооны сандал ширээ нийлүүлэх”

Тендерийн дугаар: **ЦДҮС-2019/ХА51-2**

**УЛААНБААТАР ХОТ
2019 ОН**

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019/06/26

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Цайны газрын тохижилтын иж бүрдэл, гал тогооны сандал ширээ нийлүүлэх” нийлүүлэгчийн тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийг 2019 оны 07 дугаар сарын 03-ны 09:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДҮС” ТӨХК-ний байр 3 дугаар давхар 309 тоотод 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 09:10 цагт тендерийг нээнэ.

***Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45,
“ЦДҮС” ТӨХК-ийн төв байр, 3 дугаар давхар 309 тоот.
Худалдан авах ажиллагаа, Ханган нийлүүлэлтийн хэлтэс.
Утас: 99039494. Факс:976-70043287***

Нэг.ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.




8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл



8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.



Хоёр.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ




ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> - Сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; - Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; - Ашигтай ажилласан байх жилийн тоо; /сүүлийн нэг жил/ - Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулна/ - Шүүхийн тодорхойлолт; - Татварын тодорхойлолт; - Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт; - Мэргэжлийн үйл ажиллагаандаа алдаа гаргаж байсан эсэх (харъяалах шүүхийн тодорхойлолт); - Харилцагч банкны хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тодорхойлолт. - Компанийн танилцуулга; - Нийлүүлэх бараа материалын нарийн үзүүлэлт, тоо хэмжээ, зураг зэргийг дэлгэрэнгүй ирүүлнэ; <p><i>Жич: Дээрх баримт бичгийн аль нэгийг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn -д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Огноо: 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдөр</p> <p>Цаг: 09 цаг 00 минут.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот-21013, Хан-Уул дуурэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45, “ЦДҮС” ТӨХК-ийн төв байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3-н давхар, 309 тоот</p> <p>Огноо: 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдөр нээлт хийнэ.</p> <p>Цаг: 09 цаг 10 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Цайны газрын тохижилтын иж бүрдэл, гал тогооны сандал ширээ нийлүүлэх”</p> <p>ЦДҮС-2019/ХА-51-2</p>



Гурав.БАРААНЫ ЖАГСААЛТ БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ


Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Гал тогооны тавилга	 <p>/дүйцэхүйц/</p>  	1	ком	“ЦДҮС” ТӨХК-ийн аж ахуйн хашаа	7	14	
	<ol style="list-style-type: none"> 1. Сайжруулан үртсэн шахмал хавтангаар хийх 2. Чулуун тавцантай байх 3. Судалтай шаргал өнгөтэй байх 						

	<p>4. Төмөр баруултай байх 5. Тайвшруулагчтай нугастай байх 6. Угаалтуур байршуулах 7. Дээрх зургийн дагуу хэмжээ болон дизайнтай байх</p>						
	 <p>/дүйцэхүйц/ Ширээ тавцан 1200x800 багагүй, өндөр стандарт хэмжээтэй , стандарт хэмжээтэй 4 хөлтэй түшлэгтэй 1. Сайжруулсан үртсэн шахмал хавтан байх 2. Ширээ болон сандалын хөл квадрат төмрөөр хийгдсэн байх</p>	<p>2 ширээ, 8 сандал</p>	<p>Ш</p>				
	 <p>Maronuse 92N297 эсхүл түүнтэй дүйцэхүйц Материал: Хөл хэсгийн тушаа мод улаан зандан мод.тавцан болон бусад хэсэг нь хушганы модоор урласан Онцлог: 6-10 хүн суух боломжтой олон үйлдэлтэй Хэмжээ /см/ : 200/280*100*78</p>	<p>2</p>	<p>Ш</p>				

	<p>Maronuse 192L эсхүл түүнтэй дүйцэхүйц Материал: Хушганы модоор хийгдсэн, Торгон даавуун бүрээстэй</p>	<p>14</p>	<p>Ш</p>				
	<p>Материал: Цэвэр модон хийцтэй, арьсан бүрээстэй Өнгө: Модон хийц Бор хүрэн, Бүрээс Цайвар хүрэн Хэмжээ: Гурван суудалтай 1.8м урттай 1ш, 2 суудалтай 1.2 м урттай 1ш, 1 суудалтай 0.6м урттай 1ш</p>	<p>1</p>	<p>КОМ</p>				

<p>Сэтгүүлийн ширээ</p>	 <p>/дүйцэхүйц/ Материал: Цэвэр модон хийцтэй Өнгө: Бор хүрэн Хэмжээ: 1200x600x500</p>	<p>1</p>	<p>Ш</p>				
<p>Угаалгын машин</p>	 <p>НІТАСНІ /04WHHT70KJ/ эсхүл түүнтэй дүйцэхүйц Төрөл: Хагас автомат Багтаамж /жин/: 7кг-аас багагүй Хүрдний материал: Хуванцар Хаалганы байршил: Дээрээ Эргэх хурд: 800эрг/мин- аас багагүй Өнгө: Саарал Хэмжээ : 98x83x46 см-аас багагүй</p>	<p>1</p>	<p>Ш</p>				
<p>Шилэн хаалгатай хөргөгч</p>	 <p>WestpointWPSN-2017ERT эсхүл түүнтэй дүйцэхүйц Багтаамж [л] : 156л –ээс багагүй Хэмжээ [см]: 50.5x157.5x53.8-аас багагүй</p>	<p>1</p>	<p>Ш</p>				

	Өнгө: Хар хүрээтэй шилэн нүүртэй Хүчдэлийн түвшин : 220В 50гц Цахилгаан зарцуулалт хоногт:1.2кВ/ц ихгүй						
Тумбочка	 /дүйцэхүйц/ Материал: Цэвэр модон Хэмжээ [см]: 90x100x50 Өнгө: Хүрэн Онцлог:Гурван давхар шургуулагатай	1	ш				
Цонхны хөшиг /оффис/	 Материал: Давхар ороодог жальюз Хэмжээ [см]: Өргөн 2100, Өндөр 2000 Өнгө: Цайвар шаргал торон зурвастай Онцлог: Дээшээ эвхэгддэг, хананд бэхлэнэ	2	ш				

Телевизор	 <p> SONY KD-55X8000E 4K HDR эсхүл түүнтэй дүйцэхүйц Загвар: 2018 оноос хойших шинэ Дэлгэцийн хэмжээ:55 инч /139см/ Нягтрал:4K ULTRA HD /3840x2160/ Үйлдлийн систем: Android™ Үзүүлэлтүүд: "HDR (HIGH DYNAMIC RANGE) On-board Storage (GB) 16GB SMARTPHONE холболт: Chromecast built-in, Photo Sharing Plus, Screen mirroring(Miracast™), Video & TV SideView (iOS/Android) Холболт HDMI x 4 /HDCP2.2(for HDMI™1/2/3/4) HDMI AUDIO RETURN CHANNEL (ARC) AUDIO/HEADPHONE OUTPUT(S) USB x 3 Component Video Composite Video 4K X-Reality™ PRO Live Colour™ Technology Motion enhancer Motionflow™ XR 200 (Native 50Hz) Дуугаралт: Open Baffle Speaker /10Ватт + 10Ватт/ APPLICATION STORE: (Google Play Store)" Нэмэлт төхөөрөмж: Ханын тогтоогчтой Univision гурвалсан үйлчилгээний төхөөрөмж болон 1 жилийн сунгалтын эрхтэй байх / Байгууллагад зориулсан LPLUS үйлчилгээ/ </p>	1	Ш				
-----------	--	---	---	--	--	--	--

Тав. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал
Б.Нямсамбуу танаа**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. Барааг хүлээн авахаас өмнө барааны бүрэн бүтэн байдал, тендерт санал болгосон үзүүлэлтийг хангаж буй эсэхийг шалгаж хүлээн авна. Тендерт санал болгосон үзүүлэлтээс зүүтэйгээр ирвэл нийлүүлэгч талаар солиулж хүлээн авна.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- Чанарын баталгаат хугацаа 12 сар байна. Баталгаат хугацаанд гарсан гэмтлийг нийлүүлэгч тал хариуцна. Баталгаат хугацааны барьцаа хөрөнгө гэрээний үнийн дүнгийн 5 хувь байх бөгөөд гэрээ дүгнэсэн өдрөөс хойш 06 сарын дараа олгоно.
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **95** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- Эцсийн төлбөр 5%-ийг чанарын баталгаат хугацаа дуусахад төлнө.
- Урьдчилгаа төлбөр олгохгүй.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
- 9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн **0.05%** байна.
- Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **5%**-иас хэтрэхгүй.

XXX

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __-наас _____ оны __ дугаар сарын __-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг

Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]